

Ажлын хуудас

Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл

1. Дараах агуулгыг тохирохтой нь зөв харгалзуулаарай.


1. Ажлын байран дахь хортой аюултай хүчин зүйлс гэж юу вэ?

А. Техник тоног төхөөрөмжийг зохиох, бүтээх, суурилуулах үед гардаг технологийн хязгаарлагдмал байдал

2. Юунаас болж хортой аюултай хүчин зүйлс бий болдог вэ?

Б. Органик уусгагч, хий, хүнд төмөрлөг, хортой цацраг туяа болон тоос, чимээ шуугиан, доргио зэрэг нь хүний биед хортой бөгөөд аюултай зүйлс юм.

2. Ажлын байрны физикийн хүчин зүйлд өртөх эрхтэнг сонгоно уу.



3. Хамгаалах хэрэгслийн төрлүүдийг нэрлэж бичээрэй.

1.
2.
3.
4.
5.

4. Удирдлага болон ажилчин зочдын толгой хамгаалах хэрэгслийн өнгийг зөв бичээрэй.



5. Ажиллаж байгаа орчин нөхцлөөс хамаараад хамгаалах хэрэгслээр бүрэн хангаарай.



• Дээрээс биет унаж ирэх юм уу ажилчин унаж болзошгүй ажил



• Унаж байгаа биетэд оногдох, ямар нэг биетийн завсар хавчуулагдах, тогонд цохиулах, цахилгаанжилт бий болох магадлалтай ажил



• Шуугиантай, маш чанга дуутай, сонголд цочрол үзүүлэх дуу чимээтэй ажил



• Тоосжилт хамгийн ихтэй ажил болох усан онгоцноос ачаа буулгах, ачих ажил



• Зөвшөөрөгдсөн химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх буюу ашигладаг ажил



• Тоос босдог ажил

• Битүүмжлэгдсэн орчинд байхдаа осолдсон ажилчныг аврах ажил

• Ёнкс, бойлуур, реактор зэрэг агааржуулалт муутай газар гагнуур хийх

• Подволян өрөө, траншейн нүх, бусад агааржуулалт муутай газарт хийн хоолой залгах болон таслах ажил



• Битүүмжлэгдсэн ажлын байрны хүчилтөрөгчийн концентрацийг хэмжих ажил, хэмжих багаж болон агааржуулагч төхөөрөмж шалгах ажил, ажилчинд агаар хангагч баг хэрхэн ашиглахыг заах болон ашиглалтыг шалгах ажил

• Битүүмжлэгдсэн орчинд ажил эхлэхээс өмнө хариуцсан байцаагч зэрэг хүмүүс орж хүчилтөрөгчийг концентрацийг хэмжих ажил

А. Агаар хангагч баг

Б. Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл

В. Тоос болон хорт хийнээс хамгаалах маск

Г. Тоосноос хамгаалах маск

Д. Сонголд хамгаалах хэрэгсэл

Е. Хамгаалалтын гутал

Ё. Хамгаалах дуулга

6. Хамгаалах хэрэгслийн стандартыг зөв харгалзуулах.

Хамгаалалтын хувцас ерөнхий

MNS 5623:2006

Сонсголын эрхтэнг хамгаалах нэг бүрийн

MNS 5622:2006

Амьсгалын замыг хамгаалах

MNS 5621:2006

Толгой хамгаалах

MNS /ISO13688:2000

Гарны хамгаалалт.

MNS5620:2006

Хөлний хамгаалалт, шаардлага

MNS5620:2006

7. Бичлэгээс ослын шалтгааныг тайлбарлаарай.